



2019 оны 11 дүгээр сарын 04-08

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **986** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 115(11.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 837(84.8%) хачигт халдвар, 8(0.8%) боом, 7(0.7%) тарваган тахал, 3(0.3%) хумхаа, 1(0.1%) ям, 5(0.5%) денги, 7(0.7%) бэтэг, 3(0.3%) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1 Бэтэг өвчний сэжигтэй тохиолдол


Өвөрхангай аймгийн Уянга, Хэнтий аймгийн Дадал сумаас бэтэг өвчний онош тодруулахаар 2 хүний шинжилгээний материалыг ЗӨСҮТ-д шинжлэхэд сорьцод бэтэг өвчний эсрэгбие тодорхойлогдоогүй байна.

1.2 Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол

Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 115 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2%-иар нэмэгдсэн байна.




Эпидемиологийн 44 дүгээр долоо хоногтой харьцуулахад 3 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.






1.3 Хачгаар дамжих халдварт өвчний

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 837 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.3%-иар,



Эпидемиологийн 44 дүгээр долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.



2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар ХР-ын 672 сэжигтэй тохиолдлын 135(20%), ХБ-ын 74 сэжигтэй тохиолдлын 17(22.9%), ХЭ-ын 91 сэжигтэй тохиолдлын 18(19.7%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан.

1.4 Мэрэгч амьтны дуудлага

Өнгөрсөн хоногт нийслэлийн СХД “Эмээлт” АТШН товчоо, СБД, ЧД-ээс ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага-48 ширхэг) 7 удаагийн дуудлаганд үйлчилсэн. Сорьц материалыг шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.


Он гарсаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 98 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:

Эбола вируст халдвар:


2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 3269 тохиолдол бүртгэгдсэнээс 2182(67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1841(56%) нь эмэгтэйчүүд, 926(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна. ЭМБ-ын 163(5%) ажилчид халдвар авсан байна.



Эх сурвалж: ДЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:


Япон улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 29-нд Яманаши хотын нэгэн тосгонд гахайн сонгомол мялзан өвчнөөр 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Хэл хөгрөх өвчин:

Швейцари улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 17-нд Берн тосгоны үхрийн фермд хэл хөгрөх өвчнөөр 1 үхэр өвчилж үхсэн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Рифт хөндийн чичрэг өвчин:

Судан улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 10-нд Нил мөрөн мужид рифт хөндийн чичрэг өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт 3 ямаа, 5 хонь өвчилж үхсэн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	<ul style="list-style-type: none">Белги улсЛюксембург	2019.11.04	2019.10.21	Ойд	1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	<ul style="list-style-type: none">Украйн улсЖитомир муж	2019.11.05	2019.11.04	Ойд	2 зэрлэг гахай	
ДМАЭМБ	<ul style="list-style-type: none">ОХУАмур муж	2019.11.05	2019.10.30	Тодорхойгүй	15 гахай	

Эх сурвалж: ДМАЭМБ